# БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор сумын 13 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: БНА-2024/86/НА-СТА-ТШЗ**


| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Баянхонгор хот<br>2024.02.05 | Дарга, тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат<br>Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn<br>Аудитын менежер: М.Алтантуяа<br>Утас:70442424 Цахим хаяг:@audit.gov.mn<br>Баян ташаагийн эх аудит ХХК-ийн Аудитор: Б.Хандсүрэн<br>Утас:99087198 Цахим хаяг: bte.audit@yahoo.com |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ................. Error! Bookmark not defined.**

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.................5**

**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА ................. Error! Bookmark not defined.**

**4. АУДИТЫН ТАЙЛАН ................. Error! Bookmark not defined.**

**4.1 Ерөнхий зүйл ................. Error! Bookmark not defined.**

**4.2 Материаллаг байдал ................. Error! Bookmark not defined.**

**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт ................. Error! Bookmark not defined.**

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .. Error! Bookmark not defined.**

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ................. Error! Bookmark not defined.**

**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт........ Error! Bookmark not defined.**

**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ................. Error! Bookmark not defined.**

**5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ ................. Error! Bookmark not defined.**

**5.1 Төлбөрийн акт ................. Error! Bookmark not defined.**

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ ................. Error! Bookmark not defined.**

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584
Цахим шуудан:procurement. bayankhongor@audit.gov.mn

2024. 02.23 № 2/80

танай ____________-ны № ______________ -т

БАЯНХОНГОР СУМЫН АРВАН ГУРАВ ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ Ц.ОЮУНЧИМЭГ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор сумын Арван гурав дугаар цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Баянхонгор сумын Арван гурав дугаар цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

5020299

**Аудитын гол асуудал**

Улсын төсвөөс олгосон санхүүжилт өмнөх оноос 142,676.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь Засгийн газрын 240, 241 дүгээр тогтоолын дагуу төрийн албан хаагчдын цалин хөлс нэмэгдсэнтэй холбоотой байна.

**Бусад асуудлын хэсэг**

Тайлант онд төсвийн захирагч 16 бүлэг 37 зорилтын хүрээнд 89 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас 89 арга хэмжээг бүрэн 100 хувьтай биелүүлж, биелэлтийг дээд байгууллагат хүргүүлснээр, дээд байгууллагаас 96.0 хувиар дүгнэгдсэн.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

**/ төгрөгөөр/**

| код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **87,994,412.37** | **87,529,922.70** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **27,893,081.37** | **22,255,045.70** |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | **27,893,081.37** | **22,255,045.70** |
| **3121** | **Төгрөг** | **27,893,081.37** | **22,255,045.70** |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 27,893,081.37 | 22,255,045.70 |
| **33** | **АВЛАГА** | | **495,800.00** |
| **335** | **Бусад авлага** | | **495,800.00** |
| 3351 | Байгууллагаас авах авлага | | 495,800.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **60,101,331.00** | **64,779,077.00** |
| 351 | Түүхий эд материал | 53,355,831.00 | 58,035,577.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 52,790,831.00 | 57,715,577.00 |
| 35130 | Эм боох материал | 565,000.00 | 320,000.00 |
| **354** | **Хангамжийн материал** | **6,745,500.00** | **6,743,500.00** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 204,500.00 | 202,500.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 6,541,000.00 | 6,541,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **422,887,991.68** | **403,764,290.06** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **422,887,991.68** | **403,764,290.06** |
| **392** | **Биет хөрөнгө** | **397,887,991.68** | **378,764,290.06** |
| 39 | Барилга, байгууламж, орон сууц | 457,121,172.00 | 457,121,172.00 |
| 392 | Хуримтлагдсан элэгдэл | -86,369,720.24 | -97,085,514.71 |
| 39203 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 50,507,246.77 | 50,507,246.77 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -35,008,624.66 | -39,808,545.46 |
| 39205 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 37,023,691.32 | 37,023,691.32 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -27,577,884.63 | -30,855,870.95 |
| 39207 | Бусад үндсэн хөрөнгө | 2,200,000.00 | 2,200,000.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -1,393,333.46 | -1,723,333.49 |
| 39217 | Ном | 1,385,444.58 | 1,385,444.58 |
| **39214** | **Биет бус хөрөнгө** | **25,000,000.00** | **25,000,000.00** |
| 39301 | Програм хангамж | 880,000.00 | 880,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -880,000.00 | -880,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 25,000,000.00 | 25,000,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **510,882,404.05** | **491,294,212.76** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **1,829,696.68** | |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **1,829,696.68** | |
| 413 | Өглөг | 1,829,696.68 | |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 1,829,696.68 | |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **509,052,707.37** | **491,294,212.76** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **509,052,707.37** | **491,294,212.76** |
| **511** | **Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан** | **509,052,707.37** | **491,294,212.76** |
| **51101** | Өмч: - төрийн | 25,000,000.00 | 25,000,000.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | **484,052,707.37** | **466,294,212.76** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 484,052,707.37 | 484,052,707.37 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 51220 | Тайлант үеийн үр дүн | | -17,758,494.61 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **510,882,404.05** | **491,294,212.76** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **422,370,102.50** | **479,814,560.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **13,019,702.50** | **2,394,360.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **13,019,702.50** | **2,394,360.00** |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 4,935,702.50 | 175,000.00 |
| 120042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | 175,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **409,350,400.00** | **477,420,200.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **359,187,700.00** | **443,384,900.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 359,187,700.00 | 443,384,900.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **50,162,700.00** | **34,035,300.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 50,162,700.00 | 34,035,300.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **408,979,191.63** | **497,573,054.61** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **408,979,191.63** | **497,573,054.61** |
| **2101** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **408,590,091.63** | **497,528,716.19** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **270,635,649.11** | **340,427,630.43** |
| 210101 | Үндсэн цалин | 194,567,046.11 | 222,564,758.03 |
| 210102 | Нэмэгдэл | 48,339,781.00 | 106,181,357.40 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 6,552,000.00 | |
| 210104 | Урамшуулал | 1,850,455.00 | 11,681,515.00 |
| | Гэрэт ажилчдын цалин | 19,326,337.00 | |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **32,532,107.40** | **42,599,045.24** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 21,194,064.26 | 27,650,845.24 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,772,628.81 | 3,737,400.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,860,447.31 | 2,989,800.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 611,932.12 | 746,800.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,093,034.90 | 7,474,200.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **29,361,133.80** | **31,361,264.90** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,630,703.00 | 4,803,161.58 |
| 210302 | Түлш, халаалт | 21,977,398.80 | 21,668,103.32 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,753,032.00 | 4,890,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **4,873,899.52** | **5,200,714.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 1,477,500.00 | 815,500.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернетийн төлбөр | 1,306,813.52 | 1,188,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 450,000.00 | 500,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,639,586.00 | 2,697,214.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **42,912,356.00** | **50,091,460.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,382,000.00 | 245,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 41,530,356.00 | 49,846,460.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **566,000.00** | **800,000.00** |
| 210604 | Урсгал засвар | 566,000.00 | 800,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | | **506,600.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | - | 506,600.00 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **731,500.48** | **892,600.00** |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 731,500.48 | 892,600.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **26,977,445.32** | **25,649,401.62** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,674,500.00 | 3,843,800.00 |
| 210901 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,536,200.00 | 2,681,900.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 23,766,745.32 | 19,123,701.62 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **389,100.00** | **44,338.42** |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **389,100.00** | **44,338.42** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 389,100.00 | 44,338.42 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **13,390,910.87** | **-17,758,494.61** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **13,390,910.87** | **-17,758,494.61** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН** | **416,850,400.00** | **477,595,200.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **7,500,000.00** | **175,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **7,500,000.00** | **175,000.00** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | | **175,000.00** |
| 1E+06 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | 175,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **409,350,400.00** | **477,420,200.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **359,187,700.00** | **443,384,900.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 359,187,700.00 | 443,384,900.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **50,162,700.00** | **34,035,300.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 50,162,700.00 | 34,035,300.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **388,568,218.63** | **483,188,897.25** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **388,568,218.63** | **483,188,897.25** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **388,568,218.63** | **483,188,897.25** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **270,635,649.11** | **340,427,630.43** |
| 210101 | Үндсэн цалин | 194,567,046.11 | 222,564,758.03 |
| 210102 | Нэмэгдэл | 48,339,781.00 | 106,181,357.40 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 6,552,000.00 | |
| 210104 | Урамшуулал | 1,850,455.00 | 11,681,515.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 19,326,367.00 | |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **32,532,107.40** | **43,094,845.24** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 21,194,064.26 | 28,146,645.24 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,772,628.81 | 3,737,400.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,860,447.31 | 2,989,800.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 611,932.12 | 746,800.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,093,034.90 | 7,474,200.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **27,531,437.12** | **33,190,961.58** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,630,703.00 | 4,803,161.58 |
| 210302 | Түлш, халаалт | 20,147,702.12 | 23,497,800.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,753,032.00 | 4,890,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 4,895,999.52 | |
| 210401 | Бичиг хэрэг | 1,991,500.00 | |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,306,813.52 | |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 450,000.00 | |
| **2105** | **Норматив зардал** | **39,766,825.00** | **49,846,460.00** |
| 210502 | Хоол, хүнс | 39,766,825.00 | 49,846,460.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **500,000.00** | **800,000.00** |
| 210604 | Урсгал засвар | 500,000.00 | 800,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **592,000.00** | **892,600.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 592,000.00 | 892,600.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **12,114,200.48** | **14,936,400.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 11,105,700.48 | 14,936,400.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,008,500.00 | |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **389,100.00** | **44,338.42** |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **389,100.00** | **44,338.42** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 389,100.00 | 44,338.42 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **27,893,081.37** | **-5,638,035.67** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **27,893,081.37** | **-5,638,035.67** |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **27,893,101.37** | **22,255,045.70** |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| 1 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | | | |
| 2 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | | | |
| 3 | **Тайлант үеийн үр дүн** | | | |
| 4 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **25,000,000.00** | **484,052,707.37** | **509,052,707.37** |
| 5 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **25,000,000.00** | **484,052,707.37** | **509,052,707.37** |
| 6 | Тайлант үеийн үр дүн | | -17,758,494.61 | -17,758,494.61 |
| 7 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **296,933,621.64** | **466,294,212.76** | **491,294,212.76** |

## 2.5.1 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| | ҮЗҮҮЛЭЛТ | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ | Дүн | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **505,488,300.00** | **483,068,897.25** | **22,419,402.75** | **95.6** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН** | **505,488,300.00** | **483,068,897.25** | **22,419,402.75** | **95.6** |
| **210** | **Бараа, үйлчилгээний зардал** | **505,488,300.00** | **483,068,897.25** | **22,419,402.75** | **95.6** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **356,357,300.00** | **340,427,630.43** | **15,929,669.57** | **95.5** |
| 210101 | Үндсэн цалин | 232,854,000.00 | 222,564,758.03 | 10,289,241.97 | 95.6 |
| 210102 | Нэмэгдэл | 110,935,300.00 | 106,181,357.40 | 4,753,942.60 | 95.7 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210104 | Урамшуулал | 12,568,000.00 | 11,681,515.00 | 886,485.00 | 92.9 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **47,333,100.00** | **43,094,845.24** | **4,238,254.76** | **91.0** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 32,186,400.00 | 28,146,645.24 | 4,039,754.76 | 87.4 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,787,000.00 | 3,737,400.00 | 49,600.00 | 98.7 |
| 210203 | ҮОМШӨ ний даатгал | 3,029,500.00 | 2,989,800.00 | 39,700.00 | 98.7 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 756,700.00 | 746,800.00 | 9,900.00 | 98.7 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,573,500.00 | 7,474,200.00 | 99,300.00 | 98.7 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **33,235,300.00** | **33,190,961.58** | **44,338.42** | **99.9** |
| 210301 | Гэрэл цахилгаан | 4,847,500.00 | 4,797,704.50 | 49,795.50 | 99.0 |
| 210302 | Түлш, халаалт | 23,497,800.00 | 23,503,257.08 | -5,457.08) | 100.0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,890,000.00 | 4,890,000.00 | | 100.0 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | | **3,677,400.00** | **-3,677,400.00** | |
| 210401 | Бичиг хэрэг | | 3,177,400.00 | -3,177,400.00 | |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | | 500,000.00 | 500,000.00 | |
| **2105** | **Нормативт зардал** | **51,933,600.00** | **49,846,460.00** | **2,087,140.00** | **96.0** |
| 210502 | Хоол, хүнс | 51,933,600.00 | 49,846,460.00 | 2,087,140.00 | 96.0 |
| **2106** | **Эд хогшил худалдан авах** | **800,000.00** | **800,000.00** | | **100.0** |
| 210604 | Урсгал засвар | 800,000.00 | 800,000.00 | | 100.0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр** | **892,600.00** | **892,600.00** | | **100.0** |
| 210806 | Мэдээллийн технологийн зардал | 892,600.00 | 892,600.00 | | 100.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **14,936,400.00** | **11,139,000.00** | **3,797,400.00** | **74.6** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 12,258,500.00 | 11,139,000.00 | 1,119,500.00 | 90.9 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,677,900.00 | | 2,677,900.00 | |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **477,595,200.00** | **477,595,200.00** | | **100.0** |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **477,595,200.00** | **477,420,200.00** | **175,000.00** | **100.0** |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 443,559,900.00 | 443,384,900.00 | 175,000.00 | 100.0 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 34,035,300.00 | 34,035,300.00 | | 100.0 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | | **175,000.00** | **-175,000.00** | |
| 1E+06 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | 175,000.00 | -175,000.00 | |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | **27,893,081.37** | **-27,893,081.37** | |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | **22,255,045.70** | **-22,255,045.70** | |
| 62 | АЖИЛЛАГСДЫН ТОО | 19 | 19 | | 100.0 |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 | | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 13 | 13 | | 100.0 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 5 | 5 | | 100.0 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

**3.1.1.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Баянхонгор сумын 13-р цэцэрлэг нь боловсролын салбарын бодлого, хууль тогтоомжийн хүрээнд сургуулийн өмнөх боловсролын хүрээнд мэдлэг чадвар, багшийн хөгжлийг дэмжих, хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэн ажиллах чиг үүрэгтэй байгууллага юм.

Тус байгууллага нь дараах зорилтыг хэрэгжүүлэн ажилладаг. Үүнд:

Тэдний хөгжих, төлөвших үйл явцыг шинжлэх ухааны үндэстэй удирдах, зохион байгуулах, эцэг, эх, асран хамгаалагчтай хамтран ажиллах, тэдэнд мэргэжлийн зөвлөгөө, туслалцаа дэмжлэг үзүүлэхэд оршино.

**3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Байгууллага нь үйл ажиллагаандаа Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Татварын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль 2023 оны 7 дугаар сарын 07-ны өдрөөс шинээр мөрдөгдөж эхэлсэн.
- Төрийн хэмнэлтийн тухай хууль 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

**3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор сумын 13-р цэцэрлэгийн сургуулийн өмнөх боловсролын салбарын бодлого, хууль тогтоомжийн хүрээнд 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон, шинээр батлагдсан холбогдох хууль, дүрэм, журам, заавар аргачлалын дагуу өөрчлөлтийг тусгаагүй байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

**3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлө**
2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 19,588.2 мянган төгрөгөөр буюу 3.8 хувиар буурсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт* */мянган төгрөг/*

| *Үзүүлэлт* | *Эхний үлдэгдэл* | *Эцсийн үлдэгдэл* | *Өөрчлөлт* |
|---|---|---|---|
| *Б* | *1* | *2* | *3=2-1* |
| Мөнгөн хөрөнгө | 27,893.1 | 22,255.0 | -5,638.1 |
| Авлага | - | 495.8 | 495.8 |
| Бараа материал | 60,101.3 | 64,779.0 | 4,677.7 |
| Үндсэн хөрөнгө | 574,117.6 | 574,117.6 | 0.0 |
| Хуримтлагдсан элэгдэл | -151,229.6 | -170,353.2 | -19,123.6 |
| Нийт хөрөнгө | **510,882.4** | **491,294.2** | **-19,588.2** |
| Өглөг | 1,829.7 | - | -1,829.7 |
| Засгийн газрын хувь оролцоо | 509,052.7 | 491,294.2 | -17,758.5 |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | **510,882.4** | **491,294.2** | **-19,588.2** |

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, данс байна. Тухайлбал:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 22,255.0 мянган төгрөг болж 5,638.0 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэлээр санхүүжсэнтэй холбоотой байна.
- Авлага дансны үлдэгдэл болж 495.8 мянган төгрөгөөр өссөн Нийгмийн даатгалын шимтгэлийг илүү шилжүүлсэнтэй холбоотой байна.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ

- Бараа материал дансны үлдэгдэл 64,779.1 мянган төгрөг болж, 4,677.8 мянган төгрөгөөр өссөн нь аж ахуйн материал 2.0 мянган төгрөг, эм боох материал 245.0 мянган төгрөгөөр буурч, тусгай зориулалтай материал 4,924.7 мянган төгрөөөр өөр нэмэгдсэн нь бараа материалын үлдэгдэл өссөхөд нөлөөлжээ
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өөрчлөгдөөгүй, тайлант онд 19,123.6 мянган төгрөгийн тайлант хугацааны элэгдлийн зардал 19,123.6 мянган төгрөг байна.
- Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 491,294.2 мянган төгрөг болж 17,758.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үйл ажиллагааны нийт үр дүнтэй холбоотой байна

Баянхонгор сумын 13-р цэцэрлэгийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 57,444.5 мянган төгрөгөөр өссөн, нийт зардал өмнөх оноос 88,593.9 мянган төгрөгөөр өссөн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн шууд захирагчийн 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 443,559.9 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвийг 34,035.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс улсын төсвийн санхүүжилтийг 443,559.9 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвийн санхүүжилтийг 34,035.0 мянган төгрөгөөр баталжээ.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс улсын төсвийн санхүүжилтийг 443,559.9 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвийн санхүүжилтийг 34,035.0 мянган төгрөгөөртус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 443,384.9 мянган төгрөгийн санхүүжилт бүрдүүлж цалин, нийгмийн даатгалын зардлуудад 383,522.5 мянган, нормативт зардалд 49,846.5 мянган, бараа үйлчилгээний бусад зардал 4,570.9 мянган, бараа үйлчилгээний бусад зардал 11,139.0 мянган, нийт 449,078.9 мянган төгрөгийг зарцуулж, орон нутгийн төсвөөс 34,035.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, орон нутгийн төсвөөс байр ашиглалтын зардалд 33,191.0 мянган, эд хогшил, урсгал



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ӨӨРЧЛӨЛТГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

засварын зардалд 800.0 мянган, нийт 33,991.0 мянган төгрөгийг зарцуулж 44.3 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 483,068.9 мянган төгрөг буюу 95.6 хувьтай, үүнээс орон нутгийн төсвийн нийт зардлын гүйцэтгэл 33,991.0 мянган төгрөг буюу 100.0 хувь байгаа нь улсын төсвийн зардлыг хэмнэн дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

*/мянган төгрөг/*

| Д/д | Хөтөлбөр арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 71601 | СӨБ-н үйл ажиллагааны зардал | 505,488.3 | 483,068.9 | 22,419.4 | 95.6 |
| 80101 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 490,551.9 | 471,929.9 | 18,622.0 | 96.2 |
| 83112 | Бараа үйлчилгээний бусад зардал | 14,936.4 | 11,139.0 | 3,797.4 | 74.6 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн төсөл, арга хэмжээнд 71,610.5 мянган төгрөгийг тусгаж баталснаас, гүйцэтгэлээр 61,961.8 мянган төгрөгийг зарцуулсан байна. Хүүхдийн хүнсний материал тендер шалгаруулалтыг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулж 49,846.4 мянган төгрөг, шууд худалдан авалтаар хангамж бичиг хэргийн материал 12,115.4 мянган төгрөгийн бараа материал худалдаж авсан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Баянхонгор сумын 13-р цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг 2024 оны 01 дүгээр сарын 27-ны өдрөөс 2024 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн хооронд Баян ташаагийн эх аудит ХХК-ийн аудитор Б.Хандсүрэн



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ӨӨРЧЛӨЛТГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

гүйцэтгэж, чанарын хяналтыг захирал Т.Хоролсүрэн, аудитын менежер М.Алтантуяа, дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор сумын 13-р цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 16-ний өдрийн 08 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

**4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны батлагдсан төсвөөс сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны батлагдсан төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 443,560.0 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 4,435.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материалаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70.0 хувиар буюу 3,104.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор шалгагдагч байгууллага нь нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөхгүй арга хэмжээ авч ажилласан байна.

Энэ хуулийн хүрээнд цалин, нийгмийн даатгалын зардлуудад 20,168.0 мянган, байр ашиглалтын зардлыг 44.3 мянган, нормативт зардалд 2,087.1 мянган, бараа үйлчилгээний бусад зардал 3,797.4 мянган төгрөг нийт 26,096.8 мянган төгрөгийг хэмнэж ажилласан байна.

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ӨӨРЧЛӨЛТГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллээс хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3, 6.4.5, 6.4.8 заасныг түүвэрлэн авч үзэхэд нийт 870,200.9 мянган төгрөгийн 112 мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэж заасантай нийцсэн бөгөөд аудитын үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангаж байна.

### 4.5 Засврын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Засврын аудитын талаар

Засврын аудит хийгээгүй.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон 3,592.5 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт, 2309.0 мянган төгрөгийн 3 албан шаардлагын хэрэгжилтийг 100 хувь биелүүлсэн байна.

*Хүснэгт 3 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Төлбөрийн окт | 3 | 3,592.5 | 3 | 3,592.5 | 100.0 |
| Албан шаардлага | 3 | 2,309.0 | 3 | 2,309.0 | 100.0 |
| **Нийт дүн** | **6** | **5,901.5** | **3** | **5,901.5** | **100.0** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц зүйл байхгүй.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа зөрчил илрээгүй

Тус цэцэрлэг нь үйл ажиллагааныхаа чиглэлийн дауу байгууллагын хуулийн хүрээнд болон санхүүгийн зарчмын хувьд хууль, дүрэм, журмыг зөрчөөгүй 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар материаллаг болон материаллаг бус алдаа, зөрчил илрээгүй тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгөх санал хүргүүллээ.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ӨӨРЧЛӨЛТГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ